



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 725

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мал эмнэлгийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 4 нэрийн нийт 243,877,671.25 (хоёр зуун дөчин гурван сая найман зуун далан долоон мянга зургаан зуун далан нэгэн төгрөг хорин таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 143,320,765.42 (нэг зуун дөчин гурван сая гурван зуун хорин мянга долоон зуун жаран таван төгрөг дөчин хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, хавсралтад заасан байгууллагын дарга, захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123007318
35-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 14 дугаар сарын 21 ны/ний өдрийн
7025 дугаар тогтоолын хавсралт

МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ЯАМНЫ ХАРЪЯА БАЙГУУЛЛАГА БОЛОН СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ МЭРГЭЖИЛ СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ТӨВД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Суудлын автомашинны нэр марк	Улсын		Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон огноо	Нэгж балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Хүлээн авч бүртгэх байгууллага
		дугаар	сери						
1	Тоёота ланд крузер-200	47-68	УБЭ	JTMNU09J804025482	2009/2009	55,000,000.00	25,208,333.48	29,791,666.52	Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа
2	Тоёота ланд крузер-200	05-58	УБЕ	JTMNV05J204169113	2015/2015	127,025,890.00	62,454,395.72	64,571,494.28	Хөдөө аж ахуйн корпораци
3	Тоёота ланд крузер-76	08-93	УНЛ	JTEEB71J607010101	2010/2010	20,651,781.25	14,458,036.22	6,193,745.03	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв
4	Хьюндай соната-7	08-40	УБҮ	KMNEB41ABDA516607	2012/2012	41,200,000.00	41,200,000.00	-	Сэлэнгэ аймгийн Шаамар сум дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
								100,556,905.83	
						243,877,671.25	143,320,765.42	100,556,905.83	

НИЙТ ДҮН	(хоёр зуун дөчин гурван сая найман зуун далан долоон мянга зургаан зуун далан нэгэн тегрөг хорин таван мөнгө)	(нэг зуун дөчин гурван сая гурван зуун хорин мянга долоон зуун жаран таван тегрөг дөчин хоёр мөнгө)	(нэг зуун сая таван зуун тавин зургаан есөн зуун таван төгрөг наян гурван мөнгө)	
-----------------	--	--	---	--

